



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Бага тойруу,
ШУТИС-ийн Төв номын сангийн 605
тоот

Холбогдох утас:

Төсөл хэрэгжүүлэх нэгж 11-31-55-63,
Захиргааны ажилтан Б.Номин 99710881
И-Мэйл: piu.heedproject@gmail.com

“1000 ИНЖЕНЕР-АЖЛЫН БАЙР 2023” ӨДӨРЛӨГ ЭНЭ САРЫН 25-НЫ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 10 дахь жилдээ хэрэгжүүлж буй "Инженер, технологийн дээд боловсрол" төслөөс "1000 ИНЖЕНЕР-АЖЛЫН БАЙР 2023" өдөрлөгийг 4 дэх жилдээ зохион байгуулах гэж байна.

Өдөрлөгт төслийн хүрээнд Япон Улсын Коосэн сургууль болон их сургуульд инженерийн чиглэлээр суралцаж 2023 оны 03 дугаар сард төгсөж эх орондоо ирсэн Коосэн хөтөлбөрийн 37, Бакалаврын хамтарсан хөтөлбөрийн 68, нийт 105 төгсөгч оролцох юм. Эдгээр төгсөгчид нь Япон, Англи хэлний өндөр мэдлэгтэй бөгөөд Япон Улсад 2-3 жилийн хугацаанд суралцаж барилга дэд бүтэц, механик, мэдээллийн систем, цахилгаан электроник, архитектур зэрэг мэргэжил эзэмшсэн. Бакалаврын хамтарсан хөтөлбөрийн төгсөгчдийн хувьд Япон Улсын их сургуулийн болон Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хос дипломтой төгсдөг давуу талтай.

Өдөрлөгт барилга, мэдээллийн технологи, дэд бүтэц, архитектур, уул уурхай, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын аж ахуйн нэгж, байгууллагууд оролцож төгсөгчидтэй ажлын ярилцлага хийж, сонгон шалгаруулж хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Өдөрлөгийг Төсөл хэрэгжүүлэх нэгж, Шинжлэх ухаан, технологийн их сургуультай хамтран төгсөгчдийг ажил олгогч нарт танилцуулах, ажлын байранд зуучлах, сурч, эзэмшсэн мэргэжил, мэдлэг, ур чадварыг Монгол Улсынхаа хөгжил дэвшилд ашиглах зорилгоор зохион байгуулж байгаа бөгөөд төгсөгчдийг хүссэн байгууллагадаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах боломж, бололцоог нээж өгч байгаагаараа онцлог юм.

“1000 ИНЖЕНЕР-АЖЛЫН БАЙР 2023” өдөрлөгийг 04 дүгээр сарын 25-ны өдрийн 09:30-15:00 цагийн хооронд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хичээлийн 8 дугаар байрны 12 давхарт зохион байгуулна.


---oOo---

**“1000 ИНЖЕНЕР-АЖЛЫН БАЙР 2023”
ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР**

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№	Хугацаа	Үйл ажиллагаа	
1	09:30-09:40	Нээлт	
2	09:40-09:50	1000 инженер төслийн танилцуулга	Видео үзүүлэх
3	09:50-10:00	Боловсрол, шинжлэх ухааны яамны мэндчилгээ	БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга, Төслийн захирал Х.Тамир
4	10:00-10:10	Япон талаас мэндчилгээ	Дэд тэргүүн Kikuma Shigeru үг хэлнэ ЖАЙКА
5	10:10-10:20	Ажил олгогчийн танилцуулга	М-СИ-ЭС компанийн төлөөлөл
6	10:20-10:30	Ажил олгогч мэндчилгээ, танилцуулга хийнэ	Дэнцү Дата Артист Монгол ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Э.Лхагвасүрэн
7	10:30-10:40	Grapefruit city компани танилцуулга хийнэ	Компанийн төлөөлөл
8	10:40-10:50	Хаалт	Төслийн Зохицуулагч Д.Намсрай
9	10:50-15:00	Төгсөж ирсэн оюутнууд компаниудтай уулзалт хийнэ.	Бакалавр, Коосэн хөтөлбөрийн оюутнууд

.....оОо.....



Өдөрлөг болох байршилийн зураг

